



**“ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 06

Орхон аймаг

Төлөөн удирдах зөвлөлийн цахим хурал 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 09.30 цагт эхлэв хийв. Хуралд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Батзориг, гишүүд Ж.Гэрэл, О.Бүжин, Б.Баясгаланбаатар, М.Баярцэцэг, М.Баярмаа, П.Цэрэннадмид, Г.Билгүүнээ, Ч.Баттуяа нар оролцов. Ирц 100 хувь. Компаниас гүйцэтгэх захирал Б.Бат-Эрдэнэ, Инженерийн албаны дарга П.Ганбат, Санхүү бүртгэл эдийн засаг хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Зулцэцэг, Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Ш.Зоригтбаатар нар байлцав.

Д.Батзориг: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Хурлын ирц бүрдсэн тул хурлаа эхлүүлье. Хурлаар хэлэлцэх асуудлаар нэгдсэн удирдамж батлагдсан байна. Удирдамжийг уншиж танилцуулав. /Удирдамж хавсаргав/

**Дөрөв.Хэлэлцсэн нь:** Гүйцэтгэх захирлын 2023 оны ажлын тайлан, гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний биелэлтийн тухай.

**Дөрөв.Танилцуулсан нь:** Дээрх асуудлыг Гүйцэтгэх захирал Б.Бат-Эрдэнэ танилцуулав. /холбогдох материалыг хавсаргав/

Д.Батзориг: Баярлалаа, Гишүүдээс асуулж тодруулах зүйл байна уу?

Ж.Гэрэл: Нэр дэвшүүлэх хороо дүгнэлтээ танилцуулж болох уу?

Д.Батзориг: Сонсох саналтай байна. Гишүүдэд санал байна уу? /Бүгд гар өргөж байхгүй гэв/

Танилцуулсан нь: ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны дарга Ж.Гэрэл танилцуулав. /холбогдох материалыг хавсаргав/

Д.Батзориг: Гүйцэтгэх захирлын 2023 оны ажлыг батлагдсан журмын дагуу үнэлэхэд нийтдээ 78 оноогоор хангалттай ажилласан гэж дүгнэлээ. Алдсан оноо дээрээ дараа дараагийн жилүүдэд анхаарч ажиллаарай, ажлын амжилт хүсье.

Б.Бат-Эрдэнэ: За, ойлголоо.

Д.Батзориг: Өөр асуулт, саналтай гишүүд байна уу? /Бүх гишүүд саналгүй гэв/

**Дөрөв.Шийдвэрлэсэн нь:** 1.Компанийн гүйцэтгэх захирал Бямбажав овогтой Бат-Эрдэнэтэй байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ний биелэлтийг 78 оноогоор “Хангалттай” гэж дүгнэв.

2.Компанийн гүйцэтгэх захирлын 2023 оны ажлын тайлан, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт болон компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгав.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороод даалгав.

Хурлыг 11:00 цагт хаав.

Тэмдэглэл хөтөлсөн:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ГАНЧИМЭГ